



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 0Х

Улаанбаатар хот

「Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017-2020 онд
хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр,
2017 оны зорилтын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн "д", 18.1.2-ын "а" заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх зорилтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Алдаржавхлан/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭРЭН

**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

A. ТУСГАЙ ХӨТӨЛБӨР

1. “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” хөтөлбөр
2. “Аз жаргалтай гэр бүл” хөтөлбөр
3. “Ахмадаа дээдэлбэ” хөтөлбөр
4. “Баялаг бүтээгч өрх” хөтөлбөр
5. “Хан-Уулын залуус хөгжлийн төлөө” хөтөлбөр
6. “Тохитой Хан-Уул хөтөлбөр”

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ-ӨРХ БҮРТ

- 1.1 Үйлдвэрлэлийг дэмжих
- 1.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
- 1.3 Хүнс хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх
- 1.4 Аялал жуулчлал
- 1.5 Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах
- 1.6 Дүүргийн орлого санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх

ХОЁР. ХОТ БАЙГУУЛАЛТ-ДЭД БҮТЭЦ

- 2.1 Тохиллог орчин тухтай амьдралын үндэс
- 2.2 Инженерийн шугам сүлжээний хангамжийг сайжруулах
- 2.3 Мэдээлэл технологи
- 2.4 Авто зам шинэчлэл

ГУРАВ. ЭКО ДҮҮРЭГ-НОГООН ХӨГЖИЛ

- 3.1 Хүрээлэн буй орчны тогтвортой хөгжил
- 3.2 Орчны бохирдолыг бууруулах
- 3.3 Хот тохижилт, ногоон байгууламж

ДӨРӨВ. АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ

- 4.1 Сургууль, цэцэрлэгийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх
- 4.2 Эрүүл мэнд
- 4.3 Соёл урлаг
- 4.4 Биеийн тамир, спорт
- 4.5 Хүүхэд гэр бүлийн хөгжил
- 4.6 Залуучуудын хөгжил
- 4.7 Хөдөлмөр эрхлэлт
- 4.8 Нийгмийн халамж
- 4.9 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

ТАВ. ХҮНИЙ ТӨЛӨӨ- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1 Оновчтой бүтэц, уялдаатай үйлчилгээ
- 5.2 Ухаалаг төрийн үйлчилгээ
- 5.3 Ил тод байдлыг сайжруулах
- 5.4 Тогтвортой бодлого хамтын ажиллагаа

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ-ӨРХ БҮРД

1.1 Үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр

- 1.1.1 Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр орчин үеийн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн дүүргийн бүтээн байгуулагчдыг дэмжиж ажиллана.

1.2 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр

- 1.2.1 Дүүрэгт жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих борлуулалтын нэгдсэн төвийг байгуулж, "Хан-Уул Брэндинг" шинээр бий болгоно.
- 1.2.2 Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 1.2.3 Дүүргийн иргэдийн өрхийн бизнесийг дэмжих зорилго бүхий интернэт худалдааны платформыг бий болгоно.

1.3 Хүнс хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр

- 1.3.1 Дүүргийн алслагдсан хороодод нутаг дэвсгэрийн бүсчлэлийн чиглэлээр фермерийн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх төсөл хэрэгжүүлнэ.
- 1.3.2 Дүүргийн газар тариалан эрхлэгчдийг эрсдэлээс хамгаалах үүднээс даатгалд хамруулах чиглэлээр сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.

1.4 Аялал жуулчлалын чиглэлээр

- 1.4.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор дүүрэгт соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулна.
- 1.4.2 Яармаг, Нисэхийн орчимд иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилго бүхий дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

1.5 Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах чиглэлээр

- 1.5.1 Эдийн засгийн үр ашигтай, хотын хөгжлийн томоохон цар хүрээ бүхий төсөл хөтөлбөрийг сурталчлан, хөрөнгө оруулагчдыг татах үйл ажиллагааг зохион байгуулна.



1.5.2 Дүүрэгт тулгамдаж буй асуудал /агаар, ус, хөрсний бохирдол, нийтийн тээвэр/-ыг шийдвэрлэхэд гадаад улс, хотуудын туршлагаас судалж, нэвтрүүлнэ.

1.6 Дүүргийн орлого санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр

1.6.1 Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ.

1.6.2 Иргэдийн ажиллаж амьдрах эрүүл, тохилог, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор "Орон нутгийн хөгжлийг дэмжих сан"-ийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, иргэдийн оролцоог хангаж ажиллана.

1.6.3 Орон нутгийн төсвийн орлогын баазыг өргөжүүлэн эх үүсвэрийг нэмэгдүүлж татварт хамрагдалтын төвшинг ахиулна.



ХОЁР. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ

2.1 Тохилог орчин-тухтай амьдралын үндэс

2.1.1 Дүүргийн иргэдийн судалгааг авч, нэг хашаанд олноороо амьдарч буй айл өрхүүдийн судалгаанд тулгуурлан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олгох боломжуудыг судалж шийдвэрлэнэ.

2.1.2 Залуу гэр бүл, зорилтот хэсгийг судалгаанд хамруулж үе шаттайгаар түрээсийн орон сууц болон ипотекийн зээлд хамруулна.

2.1.3 Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцнуудыг үе шаттайгаар шинэчлэнэ.

2.1.4 Хуучирсан орон сууцнуудыг сайжруулах, дулаалах ажлуудыг оршин суугчдын ойлголцол дэмжлэгт тулгуурлан хийж гүйцэтгэнэ.

2.1.5 Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох "Зөв шийдэлтэй" дахин төлөвлөлтийг системтэйгээр хийнэ.

2.2 Инженерийн шугам сүлжээний хангамжийг сайжруулах чиглэлээр

2.2.1 Гэр хорооллын айл өрхүүдийг бүрэн шаталтат зуухаар иж бүрэн хангаж, халаалтанд шингэрүүлсэн түлш болон хямд цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

2.2.2 Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр үе шаттай хангана.

2.2.3 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно.

2.2.4 Нисэх, Яармагийн гэр хорооллыг дахин төлөвлөлтөөр бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй болгох ажлыг тууштай үргэлжлүүлнэ.

2.2.5 Хороолол дундах зам талбайнус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгоно.

2.3 Мэдээлэл технологийн чиглэлээр

2.3.1 Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, захын болон алслагдсан гэр хороолол, амралт зугаалгын бүсэд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.3.2 Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангахад ухаалаг технологийг нэвтрүүлж ажиллана.



2.4 Авто зам шинэчлэлийн чиглэлээр

2.4.1 Дүүргийн замын ачаалал, орон сууц хоорондын зай талбайн байдалд иж бүрэн үнэлгээ хийж, авто замыг хөгжүүлэх шинэчилсэн төлөвлөгөө гаргана.

2.4.2 Ерөнхий төлөвлөгөө, замын сүлжээний зураг төслийн дагуу авто замыг шинээр байгуулна.

2.4.3 Явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх үүднээс "Гудамж", "Дугуйн зам" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.4.4 Дүүрэгт авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбайг иж бүрнээр нь шийдвэрлэх замаар орон сууцны гаднах ил зогсоол, машины бөөгнөрлийн асуудлыг шийдэж оршин суугчдын ая тухтай байдлыг хангана.

ГУРАВ. ЭКО ДҮҮРЭГ- НОГООН ХӨГЖИЛ

3.1 Хүрээлэн буй орчны тогтвортой хөгжлийн чиглэлээр

3.1.1 Арьс ширний үйлдвэрүүдийг дүүргийн нутаг дэвсгэрээс гаргах талаар авч хэрэгжүүлсэн шат дараатай арга хэмжээнүүдийг үргэлжлүүлж, үйлдвэрийн бохирдлыг бүрэн цэвэршүүлэх шинэ технологи нэвтрүүлнэ.

3.1.2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно.

3.1.3 Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, нөхөн сэргээлтэд тавих хяналтыг сайжруулж хариуцлагыг дээшлүүлнэ.

3.2 Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр

3.2.1 Дүүргийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх, суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна.

3.2.2 Агаарын бохирдлыг бууруулах ногоон технологи нэвтрүүлнэ.

- 3.2.3 Агаарын бохирдол үүсгэгч гэр хорооллын зуух, авто машины утаа, нам даралтат зуух зэрэг гол эх үүсвэрүүдийг хүний эрүүл мэндэд хортой байдлаар нь эрэмбэлэн тогтоож, эрүүл мэндэд хамгийн их хор хүргэж буй эх үүсвэрт анхаарал хандуулж ажиллана.
- 3.2.4 Иргэдэд экологийн боловсрол олгож, амьдралын зөв дадлыг төлөвшүүлнэ.
- 3.2.5 Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжуудын нөхцөл байдлыг стандартын шаардлагад нийцүүлнэ.

3.3 Хот тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр

- 3.3.1 Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашааны стандарт, жишгийг шинэчлэн тогтоож мөрдүүлнэ.
- 3.3.2 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авна.
- 3.3.3 Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлнэ.
- 3.3.4 Дүүргийн тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгоно.
- 3.3.5 Гэр хорооллын зам талбайг цардмалжуулах, шаардлагатай хэсгүүдийг чулуун хучилттай болгох ажлуудыг хороодын иргэдийн бүлэг, бизнес нөхөрлөлүүдээр гүйцэтгүүлнэ.
- 3.3.6 Туул, Дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулна.
- 3.3.7 Мод тарьсан, ногоон байгууламж бий болгосон иргэд, байгууллагыг урамшуулах тогтолцоог оновчтой зохион байгуулна.
- 3.3.8 Нийтийн зам талбайн бохирдол, хог хаягдлын хяналт, удирдлагын шинэ менежментийг нэвтрүүлнэ.
- 3.3.9 Дүүргийн тохижилт, архитектор-дизайн шийдлийг нэгдсэн бодлогоор хангах бүтэц бий болгон хэрэгжүүлж ажиллана.
- 3.3.10 Хог хаягдал үүсгэж, гудамж талбай бохирдуулах аливаа үйлдэлд хатуу хяналт тавьж шийдвэрлэж байх үүднээс дүүргийн байгууллага, албан газруудтай харилцан ойлголцлын гэрээ байгуулж, ахмад залуу үеийнхнээс бүрдсэн эргүүлийн баг ажиллуулан хамтарч ажиллана.
- 3.3.11 Дүүргийн хэмжээн дэх зам талбай, олон нийтийн эзэмшлийн газруудад мөрдөгдөх аюулгүйн зааварчилгаа, тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжруулна.
- 3.3.12 Нийтийн эзэмшлийн зам талбай, хороолол дундах замын тэмдэглэгээ, хаягийн стандартыг мөрдүүлж ажиллана.

ДӨРӨВ. АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ

4.1 Сургууль цэцэрлэгийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр

- 4.1.1 Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургуулийн барилгыг өргөтгөх буюу шинээр барьж, сургуулиудыг хоёр эзлжид бүрэн шилжүүлнэ.
- 4.1.2 Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө.
- 4.1.3 Хүүхэд харах үйлчилгээний стандартыг эзэмшүүлэх сургалтын нэгжүүдийг хороодын дэргэд байгуулна.
- 4.1.4 Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн талбайг шинээр барьж байгуулна.
- 4.1.5 Авто машины төвлөрөл ачааллыг бууруулах, нийтийн тээврийн соёлтой үйлчилгээг нэвтрүүлэх үүднээс дүүрэгт **Сургуулийн автобус, Богино эргэлтэт шуурхай автобус**-ыг бий болгож үйлчилгээнд нэвтрүүлнэ.
- 4.1.6 Сургуульд "Биеийн тамирын талбай", "Монгол зан заншил, соёлын төв", цэцэрлэгт "Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв" байгуулна.
- 4.1.7 Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалтын үйл ажиллагаа, чанар, ажлын үр дүнг эцэг эхийн оролцоотойгоор үнэлж дүгнэх тогтолцоог боловсруулна.

4.2 Эрүүл мэндийн чиглэлээр

- 4.2.1 Иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа үнэ төлбөргүй хамруулах, өвчнийг хянах цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- 4.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 4.2.3 Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, өртөмтгий бүлгийн иргэдийн судалгааг гарган урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жилд 1 удаа оруулж эмчилгээний хамрагдалтыг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэн өвчлөлийн төвшинг бууруулах арга хэмжээ авч ажиллана.
- 4.2.4 Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.
- 4.2.5 Хороодын өрхийн эмнэлгүүдийн үйлчилгээний стандартыг шинэ түвшинд гаргаж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд анхаарч материаллаг бааз, хүний нөөцийн ур чадвар, боловсон хүчний орон тоо, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.



4.2.6 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх тал дээр төрийн бус мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.



4.3 Соёл урлагийн чиглэлээр

4.3.1 Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян өрнүүлнэ.

4.4 Биеийн тамир, спортын чиглэлээр

4.4.1 Дүүргийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулна.

4.4.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

4.4.3 Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үндэсний болон өвөл, зуны спортын төрлийн уралдаан тэмцээн жил бүр зохион байгуулна.

4.4.4 Усан спорт сургалтын төв нэмж байгуулна.

4.5 Хүүхэд гэр бүл хөгжлийн чиглэлээр

4.5.1 Хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийн хөтөлбөрийг үндэсний өв уламжлал, ёс заншилтай хослуулан хэрэгжүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, боловсролтой, амьдрах ухаантай, эх оронч, иргэнийг төлөвшүүлнэ.

4.5.2 Хүүхдийн зуслан, тоглоомын талбай, биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн эрүүл аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална.

4.5.3 Дүүргийн хэмжээнд "Хүүхдийн авьяас төв" таваас доошгүйг байгуулна.

4.5.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд гэр бүлийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх замаар хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.

4.5.5 "Гэр бүлийн өдөр"-ийг тэмдэглэхийг хэвшүүлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгож, тогтвортой харилцааг төлөвшүүлнэ.

4.5.6 Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх санал санаачилгыг өрнүүлж, "Хүүхэд, гэр бүлд ээлтэй" байгууллага, үйлчилгээ, орчныг шалгаруулан, олон нийтэд сурталчилна.

4.5.7 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, үүнээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг эрчимжүүлнэ.

4.6 Залуучуудын хөгжлийн чиглэлээр

- 4.6.1 Залуучуудыг хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгох, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, соён гэгээрүүлэх, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулж, дугуйлан клубуудыг шинээр байгуулахыг дэмжинэ.
- 4.6.2 Оюутан залуучуудыг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, тогтвортой ажлын байраар хангах, нарийн мэргэжил эзэмшүүлэх цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.
- 4.6.3 Залуу эцэг эхчүүдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах, гэр бүлтэйгээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зориулалт бүхий төвийг нээн ажиллуулна.
- 4.6.4 Залуусын дунд мансууруулах бодисын хорт нөлөөг таниулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгааны арга хэмжээг цагдаагийн байгууллагуудтай хамтарч байнга зохион байгуулна.

4.7 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр

- 4.7.1 Өрх бүрийг судалгаанд хамруулж, ажилгүй иргэдийн мэдээллийн баазыг бий болгож, ажилгүй иргэд дүүргийн зохих албад, нэгжүүдтэй харилцах онлайн буюу шууд харилцаа үүсгэх техникийн боломжийг бүрдүүлнэ. Дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн бирж, төрийн болон төрийн бус байгууллагууд, ажил олгогчдын хамтын ажиллагааны нэгдсэн системийг бий болгоно.
- 4.7.2 Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд таатай нөхцлөөр олгох "итгэлийн зээл" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.7.3 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэн, түр болон байнгын ажлын байраар хангана.

4.8 Нийгмийн халамжийн чиглэлээр

- 4.8.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд барилга байгууламж, зам талбайн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандартыг хангуулна.
- 4.8.2 Төрийн үйлчилгээний болон төсөлт ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж ажиллана.
- 4.8.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж, алдаа дутагдлыг цаг тухай бүр нь илрүүлэн шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.

4.9 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр

- 4.9.1 Ахмадын сувилал, асрамжийн газруудыг шинээр байгуулна.
- 4.9.2 Ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.
- 4.9.3 Ахмадуудад зориулсан үйлчилгээний жишиг стандартыг боловсруулж дүүргийн төр захиргааны байгууллагуудаас эхлүүлэн нэвтрүүлж ажиллана.
- 4.9.4 Нийтийн тээврийн болон үйлчилгээний байгууллагуудад ахмадын үйлчилгээний тусгайлсан стандарт, тэмдэг тэмдэглэгээг бий болгож хэвшүүлнэ.
- 4.9.5 Ахмадуудыг нийгмийн амьдралд оролцох, өөрсдийн мэдлэг туршлагаа залуу үетэйгээ хуваалцах боломжийг хангах үүднээс "Ахмад үеэсээ суралцъя" төсөлт арга хэмжээг зохион байгуулна.



ТАВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ-ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

5.1 Оновчтой бүтэц, уялдаатай үйлчилгээний чиглэлээр

- 5.1.1 Засаг захиргааны анхан шатны нэгж-хорооны төсөв санхүү, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлнэ. Дүүргийн зарим чиг үүргийг хороодод үе шаттайгаар шилжүүлнэ.
- 5.1.2 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 5.1.3 "Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр" хэрэгжүүлж, авлигаас ангид төрийн албыг бэхжүүлсэн тунгалаг дүүрэг болно.
- 5.1.4 "Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр" боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.2 Ухаалаг төрийн үйлчилгээний чиглэлээр

- 5.2.1 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, хороодоос үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 5.2.2 Дүүргийн төрийн үйлчилгээний мэдээлэл, хяналтын автоматжуулсан системийг нэвтрүүлж, иргэдэд нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлнэ.

5.3 Ил тод байдлыг сайжруулах чиглэлээр

- 5.3.1 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэдийн мэдээллийн санг үүсгэж хувийн хэвшлийнхэнд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх системийг бий болгон үр дүнг тооцох, хяналт тавих нээлттэй засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.

- 5.3.2 Иргэдийн өргөдөл, гомдлыг хороодоор болон хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэддээ ил тод нээлттэй шийдвэрлэнэ.
- 5.3.3 Голын эрэг сав газруудыг бохирдлоос сэргийлэх үүднээс усны эрүүлгийг тогтмол ажиллуулах, үүнд дүүргийн төрийн бус байгууллагуудын оролцоог түлхүү авч ажиллана.
- 5.3.4 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ.
- 5.3.5 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах замаар ажлын байрны эмх цэгц, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.
- 5.3.6 Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.
- 5.3.7 Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох зэрэг газартай холбоотой мэдээ мэдээллийг нээлттэйгээр иргэдэд мэдээллэж ажиллана.

5.4 Тогтвортой бодлого хамтын ажиллагааны чиглэлээр

- 5.4.1 Иргэн-цэргийн харилцааг орон нутагт бэхжүүлэн, батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 5.4.2 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, хамтран ажиллах замаар "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- 5.4.3 Гэр хорооллыг камерын системд бүрэн хамруулна.
- 5.4.4 Сургууль цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбайн камержуулалтыг сайжруулна.
- 5.4.5 Төрийн үйлчилгээний нэг цэгийн төвийг дүүрэгтээ шинээр байгуулна.
- 5.4.6 Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс цагдаагийн хэсгүүдийг хороодын дунд нэмж байршуулна.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР